



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2014 оны 11 сарын 12 өдөр


Дугаар 405

Улаанбаатар хот

Г Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг төлөвлөх, хуваарилах аргачлал тухай

Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг хүн амын тоо, өвчний үе шат, тусlamж, үйлчилгээний төрөлтэй уялдуулан төлөвлөж, хуваарилах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын 8.1.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг төлөвлөх, хуваарилах аргачлалыг нэгдүгээр, өвчний үе шат, тусlamж, үйлчилгээний төрлөөр улсын хэмжээнд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг тогтоо загварыг хоёрдугаар, эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилах загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалын 1,2,3-р хавсралтаар батлагдсан аргачлал, загварын дагуу 2015 оны нэгдүгээр улиралд багтаан улсын хэмжээнд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг тогтоо, улсын хэмжээний болон тусгай үйлчилгээтэй эмнэлэг, сувиланд ашиглах орны тоог шинэчлэн тогтоо тушаалыг боловсруулж, батлуулахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Ц.Цолモンгэрэл/-т даалгасугай.
3. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний орыг энэ тушаалын 1,3-р хавсралтаар батлагдсан аргачлал, загварын дагуу эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт, батлагдсан төсөв, орны дээд хязгаартай тус тус нийцүүлж, орон нутгийн үйлчилгээтэй эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилахыг аймаг, нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын дарга нарт тус тус даалгасугай.
4. Энэ тушаалыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, зохион байгуулалт, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбогдох бэлтгэлийг хангаж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр төлөвлөлтөд тусган, хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Ц.Цолモンгэрэл/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус даалгасугай.
5. Тушаалыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, зохион байгуулалт, мэдээлэл хяналт-шинжилгээтэй холбоотой бэлтгэлийг хангаж, 2016 оны 01 дүгээр сарын сарын 01 ний өдрөөс эхлэн мөрдүүлж, ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.
6. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-т даалгасугай.



082416

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

90

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД АШИГЛАХ ОРЫГ ТӨЛӨВЛӨХ, ХУВААРИЛАХ АРГАЧЛАЛ

1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулж төлөвлөх, эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг тогтоох, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилахад энэхүү аргачлалыг баримтлана.
2. Улсын хэмжээнд ашиглах эмнэлгийн тусlamж, үйлчилгээний нийт орыг сумдын хэмжээнд, аймаг/нийслэлийн хэмжээнд, улсын хэмжээний болон тусгай үйлчилгээнд ашиглах гэсэн 3 хүрээгээр тодорхойлж, хуваарилна.
3. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орны төлөвлөлт, хуваарилалт, дээд хязгаарыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага гарвал тухайн жилд хоёроос илүүгүй удаа тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэнэ. Энэхүү өөрчлөлт нь эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглахаар тухайн жилийн батлагдсан орны дээд хязгаарын 20 хувиас хэтрэхгүй байна.
4. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг дараах ангиллаар төлөвлөж, хуваарилна.

	Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний орыг төлөвлөх, хуваарилах ангилал
1	Өдрийн эмчилгээний ор
2	Хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээний ор
	2.1 Эмнэлгийн ор
	2.1.1 Өвчний хурц (цочмог) үеийн ор
	2.1.2 Өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн ор
	2.1.3 Сүрьеэгийн ор
	2.2 Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний ор
	2.2.1 Өвчний удаан явц, архаг үеийн ор
	2.2.2 Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор
	2.2.3 Өвчний архаг үеийн уламжлалтын ор
	2.2.4 Сэргээн засах, сувилалын ор
	2.3 Сэтгэцийн ор

5. Улсын хэмжээнд ашиглах өдрийн эмчилгээний нийт орыг 10 мянган хүн амд 10 ор байхаар тооцож, төлөвлөнө.

6. Улсын хэмжээнд ашиглах эмнэлгийн нийт орыг 10 мянган хүн амд 63,0 ор байхаар тооцож төлөвлөнө. Энэ хязгаарт өөрчлөлт оруулах асуудлыг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харгалзан тухайн үед шийдвэрлэж болно.

7. Улсын хэмжээнд ашиглах эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний нийт орыг эмнэлгийн нийт орны 65%-тай дүйцэх хэмжээнээс хэтрэхгүй байхаар төлөвлөнө.

8. Улсын хэмжээнд ашиглах сэтгэцийн нийт орыг 10 мянган хүн амд 4,0 ор байхаар тооцож төлөвлөнө.

9. Орны төлөвлөлтөд ашиглах хүн амын тоог Үндэсний статистикийн хорооноос гаргасан "Хүн амын 2010-2040 оны хэтийн шинэчилсэн тооцоо"-ны төрөлтийн дундаж бууралттай үеийн Монгол улсын нутаг дэвсгэр дэх хүн амын тоог тооцсон 1Б хувилбарыг баримтлан тухайн төлөвлөлтөд хамаарч буй хугацааны сүүлийн жилийн хүн амын төсөөллийн тоог үндэслэн тооцно.

10. Өдрийн эмчилгээ, эмнэлгийн орыг тухайн сум, аймгийн хэмжээний гэж хоёр хүрээнд тусад нь тодорхойлно. Сумдын хэмжээнд ашиглах орыг тухайн сумын хүн амд, аймгийн хэмжээнд ашиглах орыг тухайн аймгийн нийт хүн амд үндэслэн тооцно.

11. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний орыг зөвхөн аймаг/нийслэлийн хэмжээнд ашиглах хүрээнд нийт дүнгээр нь хуваарилж, энэ дүнгээсээ эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилахдаа тодорхой хувийг зарим суманд давхардуулахгүйгээр хуваарилж болно.

1. Өдрийн эмчилгээний ор

1. Өдрийн эмчилгээний ор гэдэг нь үйлчлүүлэгчийг эмнэлэгт хонуулахгүй, тухайн өдөрт нь эсвэл хэд хэдэн өдрөөр үргэлжүүлэн үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг хэлнэ.
2. Өвчний түүх, сувилгааны карт нээхгүйгээр амбулаториор үзүүлэх жижиг мэс ажилбар, үйлдэл нь өдрийн эмчилгээний орны төлөвлөлтөд хамаarahгүй.
3. Өдрийн эмчилгээний ор нь эмнэлгийн орны тоонд хамаarahгүй.
4. Өдрийн эмчилгээний нийт орыг дараах томъёог ашиглан тооцно.

$$\frac{\text{Улсын хэмжээнд ашиглах өдрийн эмчилгээний нийт ор}}{= \quad \text{Хүн амын төсөөлөл}} \quad X \quad 10 \\ 10\,000$$

$$\frac{\text{Аймаг/нийслэлийн өдрийн эмчилгээний ор}}{= \quad \text{Хүн амын төсөөлөл}} \quad X \quad 5 \\ 10\,000$$

$$\frac{\text{Улсын болон тусгай үйлчилгээнд ашиглах өдрийн эмчилгээний ор}}{= \quad \text{Улсын хэмжээнд ашиглах өдрийн эмчилгээний нийт ор}} \quad \frac{\text{Аймаг/нийслэлийн хэмжээнд ашиглах өдрийн эмчилгээний ор}}{- \quad \text{Сумдад ашиглах өдрийн эмчилгээний ор}}$$

Сумдын өдрийн = Хүн амын төсөөлөл
эмчилгээний ор 10 000

X 8

5. Өвчний дэгдэлт, олныг хамарсан өвчлөлийн үед өдрийн эмчилгээний орыг түр хугацаагаар нэмж ажиллуулж болно. Үүнийг тухайн эрүүл мэндийн байгууллага батлагдсан төсөвтөө багтааж, шийдвэрлэнэ.

2. Хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээ

2.1. Эмнэлгийн ор

1. Эмнэлгийн ор гэдэг нь өвчтнийг эмнэлэгт 24 цагаас дээш хугацаанд хэвтүүлж эмчлэхэд зориулж бэлтгэсэн, хүний нөөцөөр хангагдсан, өвчтнийг шууд хүлээн авах боломжтой, жилийн туршид тогтмол ажиллах орыг хэлнэ.
2. Эмнэлгийн орыг дотор нь 1) өвчний хурц(цочмог) үеийн эмчилгээний ор, 2) өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээний ор, 3) сурьеэгийн эмчилгээний ор гэсэн ангиллаар төлөвлөж, хуваарилна.
3. Өдрийн эмчилгээний ор, эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний ор, сэтгэцийн ор, түр хугацаагаар ажиллуулах орыг эмнэлгийн орны тоонд оруулахгүй. Мөн тусгай зориулалтын ор (гемодиалез, мэс заслын ширээ/ор, төрөх өрөөний үзлэгийн ор, эмэгтэйчүүдийн үзлэгийн ор, күшетка, дамнуурга, 24 цагийн доторх ажиглалтын ор, эхийн амрах байрны ор, эрүүл нярайн ор) болон ямар нэг шалтгаанаар ашиглагдахгүй байгаа орыг эмнэлгийн орны тоонд оруулахгүй.
4. Өвчний дэгдэлт, гамшиг, осол, олныг хамарсан өвчлөлийн үед тухайн эмнэлэг тусlamж, үйлчилгээний ачааллыг харгалзан зөвшөөрөгдсөн орны 10% хүртэлх тооны эрсдлийн орыг тухайн эрүүл мэндийн байгууллага батлагдсан төсөвтөө багтаан түр хугацаагаар нэмж ажиллуулж болно. Түр хугацаагаар нэмж ажиллуулах ор нь нийт эмнэлгийн орны 10%-иас дээш тооны бол түүний төсөв, санхүүжилт шийдвэрлэгдсэний дараа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын зөвшөөрөлтэйгээр ажиллуулна.
5. Эмнэлгийн нийт орны фонд ашиглалтын хувь улсын хэмжээнд 85%-иас, нийслэлийн хэмжээнд 90%-иас, аймгийн хэмжээнд 85%, сумын хэмжээнд 80%-иас өндөр тохиолдолд эмнэлгийн ачааллыг бууруулах бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх, боломжгүй тохиолдолд орны тоог нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
6. Эмнэлгийн орны фонд ашиглалтын хувь улсын хэмжээнд 65%, нийслэлийн хэмжээнд 65%, аймгийн хэмжээнд 60%, сумын хэмжээнд 50%-иас бага тохиолдолд ор бууруулснаас үйлчлүүлэгчдэд учирч болзошгүй эрсдлийг тооцож, орны тоо бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.1.1 Өвчний хурц (цочмог) үеийн ор

1. Өвчний хурц (цочмог) үеийн ор гэдэгт аливаа өвчин эмгэгийн хурц үед оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын дагуу өвчин эмгэгийн явцаас хамааран орчин үеийн болон уламжлалт аргаар эмнэлэгт 18 хоног хүртэл хэвтүүлэн эмчлэх орыг хамруулна.
2. Өвчний хурц (цочмог) үеийн орыг эх, нярайн тусламж, үйлчилгээ, үйлчлүүлэгчдэд цочмог өвчин эмгэг үүсэх, гэмтэл бэртэлд өртөх, архаг өвчин сэдрэх, өвчин эмгэгийн ээнэгшил алдагдах, хүндрэх, яаралтай болон амь тэнссэн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийг 24 цагаас дээш хугацаанд ажиглах, тусгаарлахад ашиглана.
3. Өвчний хурц (цочмог) үеийн орыг дараах томъёог ашиглан тооцно.

Улсын хэмжээнд ашиглах
өвчний хурц үеийн = Нийт хүн амын төсөөлөл
10 000 X 50

Аймаг/нийслэлд
ашиглах өвчний
хурц үеийн ор = Тухайн орон нутгийн хүн амын төсөөлөл
10 000 X 30

Сумдад ашиглах
өвчний хурц
үеийн ор = Тухайн орон нутгийн хүн амын төсөөлөл
10 000 X 30

Улсын хэмжээний болон тусгай үйлчилгээнд ашиглах хурц үеийн ор	=	Улсын хэмжээнд ашиглах өвчний хурц үеийн нийт ор	Аймаг/нийслэлд ашиглах өвчний хурц үеийн ор	Сумдад ашиглах өвчний хурц үеийн ор
----------------------------------------------------------------------------	---	-----------------------------------------------------------	---------------------------------------------------------	-------------------------------------------

12. Улсын хэмжээнд ашиглах өвчний хурц (цочмог) үеийн эмчилгээний нийт орны 70%-иас доошгүй нь орон нутагт (аймгийн төв, дүүрэг, сум, тосгон) хуваарилагдана.

13. Нийт эмнэлгийн орны 80%-иас доошгүй нь өвчний хурц (цочмог) үед ашиглахад зориулагдана.

2.1.2 Өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн ор

1. Өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн ор гэдэгт аливаа өвчин эмгэгийн хурцавтар үед эмнэлзүйн эрт үеийн сэргээн засах, уламжлалт, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх, хавдар, цусны эмгэг, түлэгдэлт, мэс заслын дараах хүндрэл зэрэг удаан явцтай өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын дагуу эмнэлэгт 18-аас дээш хоног хэвтүүлэн эмчлэх орыг хамруулна.
2. Өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн ор нь тухайн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн орны 20%-иас хэтрэхгүй байна.

3. Улсын хэмжээнд ашиглах өвчний хурцавтар (цочмогдуу) үеийн орны 75%-иас доошгүй нь орон нутагт /аймаг, дүүрэг, сум, тосгон/ хуваарилагдсан байна.
4. Энэхүү ангиллын орыг дараах томъёог ашиглан тооцно.

Улсын хэмжээнд ашиглах
өвчний хурцавтар
үеийн нийт ор = Нийт хүн амын төсөөлөл
10 000 X 10

Аймаг/нийслэлд
ашиглах өвчний = Тухайн орон нутгийн
хүн амын төсөөлөл X 10

Сумдад
ашиглах өвчний = Тухайн орон нутгийн
хурцавтар үеийн ор хүн амын төсөөлөл X 6
10 000

Улсын хэмжээний болон тусгай үйлчилгээнд ашиглах өвчний хурцавтар үеийн ор	Улсын хэмжээнд ашиглах өвчний - хурцавтар үеийн нийт ор	Аймаг/нийслэлд ашиглах өвчний хурцавтар үеийн ор	Сумдад ашиглах өвчний хурцавтар үеийн ор
----------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------	---------------------------------------------------

2.1.3 Сурьеэгийн ор

- Сурьеэгийн эмчилгээний эмнэлзүйн удирдамж, стандарт, зааврын дагуу эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх орыг энэхүү ангилалд оруулан тооцно.
- Сурьеэгийн тусламж, үйлчилгээг сумдад өдрөөр болон гэрээр үзүүлэх боломжтой тул сурьеэгийн ор хуваарилахгүй.
- Эмнэлгээс гарсны дараах сурьеэгийн үргэлжлэх шатны эмчилгээ, хөнгөвчлөх, сэргээн засах, сувиллын үйлчилгээг эмнэлгээс гарсны дараах урт хугацааны тусламж, үйлчилгээний тухайн ангилалд нь оруулж тооцно.
- Сурьеэгийн эмчилгээг бусад ангиллын орыг ашиглаж, хавсран үзүүлэх тохиолдолд энэ ангилалд давхардуулж тооцохгүй. Тухайлбал: Сэтгэцийн ор ашиглаж эмчлүүлж байгаа өвчтөнд сурьеэгийн эмчилгээ хавсран хийгдэх бол ор нэмэх үндэслэл болохгүй.
- Эмнэлэгт үзүүлэх сурьеэгийн тусламж, үйлчилгээний орыг дараах томъёог ашиглан тооцно.

Улсын хэмжээнд ашиглах
сурьеэгийн нийт ор = Нийт хүн амын төсөөлөл
10 000 X 3

Аймагт ашиглах
сурьеэгийн ор = Хүн амын төсөөлөл
10 000 X 1,5

Нийслэлд ашиглах
сурьеэгийн ор = Хүн амын төсөөлөл
10 000 X 0,5

Улсын хэмжээний болон тусгай үйлчилгээнд ашиглах сурьеэгийн ор	=	Улсын хэмжээнд ашиглах сурьеэгийн нийт ор	-	Аймагт ашиглах сурьеэгийн ор	+	Нийслэлд ашиглах сурьеэгийн ор
----------------------------------------------------------------	---	-------------------------------------------	---	------------------------------	---	--------------------------------

2.2 Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний ор

1. Эмнэлгээс гарсны дараах эмчилгээ, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, архаг өвчний сэдрэлээс сэргийлэх, өвчний намжмал байдал, ээнэгшлийн үеийг уртасгах, үйлчлүүлэгчийн өөрөө өөртөө үйлчлэх чадварыг сэргээх, архаг хүнд өвчний өвдөлт, зовиур шаналгааг арилгах, амьдралын төгсгөлийн шатанд хөнгөвчлөх зорилгоор хэвтүүлэн эмчлэх тусlamж, үйлчилгээнд энэхүү орыг ашиглана.

2. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний орыг тухайн үйлчлүүлэгчийн биеийн байдал, өөрөө өөртөө үйлчлэх чадвар, өвчин эмгэгийн даамжралаас шалтгаалан 1/нэг дор олон хоногоор хэвтүүлэх, эсвэл 2/тодорхой давтамжтайгаар хэвтүүлж, урт хугацаанд үргэлжлүүлэн үзүүлэх гэсэн хоёр хэлбэрээр үзүүлнэ.

3. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний ор нь 1)өвчний удаан явц, архаг үеийн ор, 2)хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор, 3)өвчний архаг үеийн уламжлалтын ор, 4)сэргээн засах, сувиллын ор гэсэн төрлүүдтэй байна.

4. Энэхүү тусlamж, үйлчилгээнд хуваарилагдах нийт ор нь тухайн хүрээний эмнэлгийн орны 65%-тай дүйцэх хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцно. Үүнийг дараах харьцаагаар тооцож хуваарилна.

65%	=	25%	+	5%	+	10%	+	25%
Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний нийт ор		Өвчний удаан явц, архаг үеийн ор		Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор		Өвчний архаг үеийн уламжлалтын ор		Сэргээн засах, сувиллын ор

5. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны тусlamж, үйлчилгээний үргэлжлэх хугацаа, дундаж ор хоног нь тухайн өвчтний биеийн байдал, өвчний хүндрэл, амьдралын чухал эрхтнүүдийн үйл ажиллагаа сэргэж буй байдал, үйлчлүүлэгч өөрөө өөртөө үйлчлэх чадвараас хамаарах тул ор хоногийн дээд хязгаарыг тогтоохгүй.

6. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны эмчилгээний орны фонд ашиглалтын хувь тухайн орон нутгийн хэмжээнд 80%-иас дээш тохиолдолд ачааллыг бууруулах бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, боломжгүй тохиолдолд орны тоог нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

7. Эмнэлгээс гарсны дараах болон урт хугацааны эмчилгээний орны фонд ашиглалтын хувь тухайн орон нутгийн хэмжээнд 60%-иас бага тохиолдолд ор бууруулснаас гарах эрсдлийг тооцож, орны тоог бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.2.1 Өвчний удаан явц, архаг үеийн ор

1. Эмнэлгээс гарсны дараах өвчний эдгэрэлтийн явц удаашрах болон архаг өвчний үеийн тусlamж, үйлчилгээнд ашиглах орыг хамруулна.
2. Өвчний удаан явц, архаг үеийн ор нь эмнэлгээс гарсны дараах эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу шаардлагатай эмчилгээ, асаргаа, сувилгааг хийх, архаг өвчний сэдрэлээс сэргийлэх түүний намжмал байдал, ээнэгшлийн үеийг уртасгах зорилго бүхий тусlamж, үйлчилгээнд ашиглана.
3. Энэ тусlamж, үйлчилгээг бусад ангиллын орыг ашиглаж, хавсран үзүүлэх тохиолдолд энэ ангилалд давхардуулж тооцохгүй. Тухайлбал: Өвчний архаг үеийн уламжлалтын ор, хөнгөвчлөх, асаргаа, сувилгааны орыг ашиглаж, энэхүү үйлчилгээг хавсран үзүүлж байгаа бол орны тоо нь тухайн үндсэн үйлчилгээг үзүүлж буй ангилалдаа орж тооцогдсон гэж үзнэ.
4. Тухайн аймгийн өвчний удаан явц, архаг үеийн нийт ороос аймгийн төвөөс 50км-ээс дээш алслагдсан сумдад давхардуулахгүйгээр хуваарилж болно.
5. Өвчний удаан явц, архаг үеийн орыг нийт эмнэлгийн орны 25%-тай дүйцэх хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож төлөвлөнө.
6. Өвчний удаан явц, архаг үеийн орыг хуваарилахдаа аймаг, нийслэл, улсын хэмжээний болон тусгай үйлчилгээ гэсэн 3 хүрээ тус бүрийн эмнэлгийн орны 25%-тай дүйцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, хуваарилна.

3.2 Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор

1. Архаг хүнд өвчтэй буюу амьдралын төгсгөлийн шатанд байгаа үйлчлүүлэгчид хөнгөвчлөх тусlamж, үйлчилгээ болон асаргаа сувилгаа хийж, сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд энэхүү орыг ашиглана.
2. Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны орыг хуваарилахад тухайн тусlamж, үйлчилгээний тэгш байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор уг чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагуудад түлхүү хуваарилна.
3. Тухайн аймгийн энэхүү ангиллын ороос аймгийн төвөөс 50 км-ээс дээш алслагдсан сумдад давхардуулахгүйгээр хуваарилж болно.
4. Эдгээр тусlamж, үйлчилгээг бусад ангиллын орыг ашиглаж тусlamж, үйлчилгээг хавсран үзүүлэх тохиолдолд энэ ангилалд давхардуулж тооцохгүй. Тухайлбал: Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор ашиглан уламжлалтын тусlamж, үйлчилгээг хавсран үзүүлж байгаа нь ор нэмэх үндэслэл болохгүй.
5. Хөнгөвчлөх, сувилгаа, асаргааны ор нь 10 мянган хүнд 3,0 ор байхаар буюу эмнэлгийн нийт орны 5%-тай дүйцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцно.

6. Энэ ангиллын орыг хуваарилахад сум, аймаг/нийслэл, улсын хэмжээний болон тусгай үйлчилгээ гэсэн 3 хүрээ тус бүрийн эмнэлгийн орны 5%-тай дүйцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, хуваарилна.

3.3 .Өвчний архаг үеийн уламжлалтын ор

1. Өвчний архаг үед тодорхой давтамжтайгаар урт хугацаанд үргэлжлүүлэн эмчлэх, сувилах шаардлагатай уламжлалт эмчилгээний орны тоог нийт эмнэлгийн орны 10%-тай дүйцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, хуваарилна.
2. Энэ ангиллын орыг хуваарилахад аймаг, нийслэл, улсын болон тусгай үйлчилгээний хүрээ тус бүрийн эмнэлгийн орны 10%-тай дүйцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, хуваарилна.
3. Энэхүү тусламж, үйлчилгээг бусад ангиллын эмнэлгийн ор ашиглаж хавсран үзүүлэх тохиолдолд уг орыг энэ ангилалд давхардуулж тооцохгүй. Тухайлбал: Өвчний удаан явц, архаг үеийн эмчилгээний ор, өвчний хурцавтар үеийн эмнэлгийн ор, сэргээн засах, сувиллын орыг ашиглаж уламжлалтын үйлчилгээг хавсран үзүүлж байгаа тохиолдолд уг орны тоо нь тухайн үндсэн үйлчилгээг үзүүлж буй ангилалдаа орж тооцогдсон гэж үзнэ.
4. Энэхүү ангиллын орыг орон нутагт аймгийн төвөөс 50 км-ээс дээш алслагдсан сумдад давхардуулахгүйгээр хуваарилж болно.

3.4 Сэргээн засах, сувиллын ор

1. Сэргээн засах, сувиллын орны тоог нийт эмнэлгийн орны 25%-тай тэнцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, төлөвлөнө.
2. Энэ ангиллын орыг хуваарилахад аймаг, нийслэл, улсын хэмжээний үйлчилгээнд ашиглах хүрээ тус бүрийн эмнэлгийн орны 25%-тай тэнцэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тооцож, хуваарилна.
3. Тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа сувилалд үйлчлэх хүрээний хүн амаасаа хамааран аймаг, нийслэлд болон улсын хэмжээнд үйлчлэх аль нэг хүрээнд давхардуулахгүйгээр хуваарилна.
5. Эдгээр тусламж, үйлчилгээг бусад ангиллын орыг ашиглаж хавсран үзүүлэх тохиолдолд уг орыг энэхүү ангилалд давхардуулан тооцохгүй. Тухайлбал: Өвчний удаан явц, архаг үеийн эмчилгээний ор, өвчний хурцавтар үеийн эмнэлгийн ор ашиглаж, уг үйлчилгээг хавсран үзүүлж байгаа бол орны тоо нь тухайн үндсэн үйлчилгээг үзүүлж буй ангилалдаа орж тооцогдсон гэж үзнэ.

2.3 Сэтгэцийн ор

1. Сэтгэцийн өвчний хэвтүүлэн эмчлэх бүх төрлийн тусламж, үйлчилгээг энэхүү ангилалд хамруулах ба уг ор нь эмнэлгийн орны тоонд тооцогдохгүй.

2. Сэтгэцийн орны тоонд сэтгэл заслын өдрийн эмчилгээний орыг оруулахгүй.
Энэхүү ор нь өдрийн эмчилгээний оронд тусгагдсан гэж үзнэ.
3. Сэтгэцийн орыг дараах томъёог ашиглан төлөвлөж, хуваарилна

$$\text{Сэтгэцийн нийт ор} = \frac{\text{Хүн амын төсөөлөл}}{10\,000} \times 4$$

$$\text{Аймаг, нийслэлийн} = \frac{\text{Хүн амын төсөөлөл}}{10\,000} \times 2$$

$$\begin{array}{lcl} \text{Улсын хэмжээний} & \text{Улсын хэмжээнд} & \text{Аймаг, нийслэлд} \\ \text{болов тусгай} & \text{ашиглах} & \text{ашиглах сэтгэцийн} \\ \text{үйлчилгээнд} & = \text{сэтгэцийн} & \text{оп} \\ \text{ашиглах сэтгэцийн} & \text{нийт оп} & \end{array}$$

4. Сэтгэцийн нийт орны 60%-иас доошгүй нь аймаг, нийслэлд хуваарилагдана. Сумдад сэтгэцийн орыг хуваарилахгүй.

5. Сэтгэцийн орны фонд ашиглалтын хувь улсын хэмжээнд 80%-иас дээш тохиолдолд, ачааллыг бууруулах бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, боломжгүй тохиолдолд орны тоог нэмэгдүүлэх асуудлыг шийднэ.

6. Сэтгэцийн орны фонд ашиглалтын хувь улсын хэмжээнд 60%-иас бага тохиолдолд оп бууруулснаас гарах эрсдлийг тооцож, оп бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
... сарын 25. едрийн дугаар
тушаалтын 2 дугаар хавсралт

ӨВЧНИЙ ҮЕ ШАТ, ТУСЛАМЖ, УЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР УЛСЫН ХЭМЖЭЭНД
АШИГЛАХ ЭМНЭЛЭГ, СУВИЛЫН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ЗАГВАР

Д/Д	Тусlamж, уйлчилгээний хүрээ	Эмнэлгийн ор		Хэвтүүлэн эмчлэх тусламж, уйлчилгээний ор		Сэргээн засах, сувиллын ор
		Өвчиний хурц (цочмог) үеийн ор	Өвчиний хурцавтар (цочмогуу) үеийн ор	Сурьеэгийн ор	Өвчиний удаан явлцархаг үеийн ор	
.....	аймгийн сумдын хэмжээнд ашиглах ор					
.....	аймгийн хэмжээнд ашиглах ор					
	Нийслэлийн хэмжээнд ашиглах ор					
	Улсын хэмжээний болон тусгай уйлчилгээнд ашиглах ор					
	Улсын хэмжээнд ашиглах нийт ор					



Эрүүл мэндийн сайдын 2014 оны
сарын 22-р сардийн 22-дугаар
тушаалын здугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЫГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛАГУУДАД ХУВААРИЛАХ ЗАГВАР